

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2019 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар A/02

Улаанбаатар
 хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар болон Төв аймгийн Засаг даргын тамгын газар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллах, хяналтыг сайжруулах, Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллахад Энэхүү санамж бичгийн зорилго оршино.

Хоёр. Талуудын хамтын ажиллагааны чиглэл

2.1 Талууд дараах үйл ажиллагаанд хамтран ажиллана:

2.1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон бусад хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах, хуулийн биелэлтийг хангаж ажиллах, хэрэгжилтэд хяналт тавихад хамтран ажиллах;

2.1.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суухтай холбоотойгоор орон нутгаас баримтлах бодлого, үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, хамтран хяналт тавьж, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад хамтран ажиллах;

2.1.3. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад хамтран ажиллаж тусламж, дэмжлэг үзүүлэх;

2.1.4. Байгууллагын орчны тохижилт, цэцэрлэгжилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.1.5. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд орлогыг бүрдүүлэхэд хуулийн хүрээнд хамтран ажиллах;

2.1.6. Талууд Энэхүү санамж бичгийн зорилгыг хангахын тулд бүх шатанд ил тод, нээлттэй, багаар хамтран ажиллахыг эрмэлзэх.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1 Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь:

3.1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон бусад хууль тогтоомжийг сурталчлах ажлыг орон нутагт зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангах энэ талаар орон нутгийн иргэд, аж ахуй нэгж, оршин суугчдын мэдлэг, чадамжийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.1.2. Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад хөрөнгө оруулалт хийх;

3.1.3. Гадаадын иргэн, харьяатын газрын төв байрны хүрээлэн буй орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх;

3.1.4. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, зуслангийн газар эзэмшигүүлэхэд туслалцаа үзүүлэх;

3.1.5. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж байгууллагуудад нутгийн захиргааны байгууллагаас гаргасан санал, хүсэлт, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зөвлөгөө, мэдээлэл өгөх, хамтран ажиллах;

3.1.6. Санамж бичигт тохиролцсон асуудлуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн бичиг баримтыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанд уламжилж, шийдвэр гаргуулах.

3.2. Гадаадын иргэн, харьятын газар нь:

3.2.1 Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай болон бусад хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах, хуулийн биелэлтийг хангаж ажиллахад сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.2.2 Орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах бөгөөд энэхүү ажлыг тус байгууллагын Агаарын замын боомт хариуцсан газартай хамтран гүйцэтгэх;

3.2.3 Бүх нийтийн их цэвэрлэгээ, мод тарих, ногоон байгууламж бий болгох зэрэг тохижилтын ажилд байгууллагын ажилтан, албан хаагчдаа хамруулж хамтран ажиллах;

Дөрөв. Бусад зүйл

4.1. Энэхүү Санамж бичигт талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 1 жилийн хугацаагаар байгуулав.

4.2. Талууд Санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд санаалаа харилцан зөвшилцэж шийдвэрлэх ба энэ нь бичгээр баталгаажуулж, талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.3. Энэхүү санамж бичгийг 2 хувь үйлдэх бөгөөд Талууд нэг нэг хувийг хадгална.

4.4. Санамж бичигт дурдсан асуудлын хэрэгжилтийн явц, биелэлтийг талуудын Тамгын асуудал хариуцсан нэгжүүд хариуцан ажиллах бөгөөд хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор талуудын удирдлагуудад танилцуулна.

4.5. Талууд Санамж бичгийн дагуу олж авсан мэдээллийг харилцан зөвшилцэхгүйгээр бусдад ашиглуулах, задруулахыг хориглох бөгөөд задруулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэнэ.

4.6. Талууд Санамж бичигт заасны дагуу хэрэгжүүлж буй ажилтай холбоотой аливаа асуудал, маргаан, үл ойлголцлыг харилцан зөвшилцэл, ойлголцол, итгэлцлийг эрхэмлэх зарчмаар шийдвэрлэнэ.

САНАМЖ БИЧГИЙГ БАЙГУУЛСАН:

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА



Д.МОРОН